

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Долдон	Дугаар	L342
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Баянжаргалан сум
Төрсөн газар	Баянжаргалан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уулын жас, Мужийн жас	Сүм хийдийн дугаар	ДУБЖ 069, ДУГС 055
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 1	Ярилцлага авсан хүн	Жужа, Энхбаяр

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Мужийн жас, Уулын жас

Жужа: Долдон гуйн ач охин нь асуултыг дамжуулж хариу өгч байсан байна.

Энхбаяр: Уулын жасын тухай, таниас бид лавлаж асууя . Энэ жас яг хаана байсан бэ?

Долдон: Энд байсан, энэ бригадаас баруун урагшаа байсан.

Энхбаяр: Хэдэн дугантай байсан бэ?

Долдон: Ганц чулуун дуган байсан. Бас хэдэн жижиг шавар, чулуун байсан.

Энхбаяр: Гэр байсан уу?

Долдон: Аа гэр байлгүй дээ. Мал идээтэй нутгийн хүмүүс.

Энхбаяр: Тэнд хоёр овоо байна лээ. Ямар нэртэй овоо вэ?

Долдон: Аа мэдэхгүй. Уулын л овоо гэдэг юм ш дээ. Үгүй би чинь насаараа мал дагасан хөдөөний хар хүн. Жас хурлын талаар юу ч мэдэхгүй. Хэдэн ламтай, нэг дуган л байсан гэхээс цааш юм байхгүй. Харин энэ тухай сайн мэдэх хүн чинь энэ Жамбасамбуу. Одоо сумын төв дээр байгаа Шар Довдон хоёр л мэднэ. Хоёулаа энд сууж байсан лам хүмүүс, Шар довдон бол бүр илүү сайн мэднэ.

Энхбаяр: Танай энэ гадаа энүүхэнд нэг суварга байх юм. Ямар учиртай суварга вэ?

Долдон: Үгүй ээ энд нэг суварга намайг мэдэхийн л байдаг байсан юм. Хүмүүс Суварган жас л гэж нэрлэдэг юм.

Хажууд нь нэг худаг бий. Суварганы худаг гэдэг юм. Бас нэг дуган байсан санагддаг юм.

Энхбаяр: Тэгвэл жас байж дээ, лам нар байсан уу, хурал хурж байсан уу?

Долдон: Өө байнга лам нар байхгүй. Хааяа хааяа л хэдэн лам нар ирж хурал хурдаг байсан санагдаж байна.

Энхбаяр: Тахилч лам байсан биз дээ?

Долдон: Аан, даянч лам аа ?

Энхбаяр: Үгүй, үгүй. Тахилч лам , ганцаараа дуганыг харж байдаг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Долдон: Аа сахиул лам байсан. Нэг лам байсан, нэр нь хэн билээ дээ мартчихаж.

Энхбаяр: Мужийн жас хэдэн дугантай байсан бэ?

Долдон: Дуган байхгүй байсан байх аа. Хэдэн жижиг шавар байшин л байсан. Намайг цэрэгт яваад ирэхэд л лам нар нь баригдах нь баригдаад, алагдах нь алагдаад энэ Уулын жас, Мужийн жас энэ тэр чинь юу ч үгүй болчихсон байсан. Хэдэн шавар байсан л үлдсэн байсан. хамгийн сүүлд л энэ Уулын жасыг байхгүй болгосон гэдэг. Би бол ер нь үүнээс өөр юу ч мэдэхгүй, та нарт Жамбасамбуу, Шар Довдон хоёроос өөр энэ тухай ярьж өгөх хүн байхгүй. Хоёулаа энд сууж лам хувраг явсан хүмүүс. Шар Довдон сумын төв дээр сууж байгаа. Хүнтэй ярихад их хэцүү болсон. Ер юм сонсохоо байсан, чих нь дүлий болсон. Уг нь тэр хүн л илүү сайн мэдэх ёстой. За нэг иймэрхүү л байна.